



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/502

Арвайхээр

**Дуудлага худалдаа дахин зохион  
байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 25 дугаар тогтоолын 3.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн “Үндсэн хөрөнгө дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай” 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагаас ирсэн санал, Хархорин сумын 1 дүгээр цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 33,712,000 (гучин гурван сая долоон зуун арван хоёр мянга) төгрөгийн үнэ бүхий 2408 м<sup>2</sup> газрыг дуудлага худалдаагаар худалдсугай.

2. Газрын биржийн цахим системийг ашиглан дуудлага худалдааг 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулсугай.

3. Хөрөнгийн дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, орлогыг “Орон нутгийн өмч худалдсаны орлого” дансанд төвлөрүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (З.Балданням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101064